

Үндэсний статистикийн хорооны даргын  
2013 оны 11-р сарын 20-ны өдрийн 1/131 тоот  
тушаалаар батлав.

**Маягт НЗҮ-1**

1. Сум, дүүргийн засаг дарга нар нэгтгэж 12 дугаар сарын 25-нд аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтэст маягтаар хүргүүлнэ.
2. Аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтэс нь дараа жилийн 01 дүгээр сарын 04-ний дотор Үндэсний статистикийн Хороонд цахим шуудангаар ирүүлнэ.

Мэдээллийн нууцыг Монгол Улсын "Хувь хүний нууцын тухай" хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын "Статистикийн тухай" хуулийн 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу өрх, хүн бүрийн мэдээллийн нууцыг чандлан хадгална.

## НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТИЙН 20... ОНЫ МЭДЭЭ

### А.ХАЯГИЙН ХЭСЭГ

	Нэр	Код
Аймаг, нийслэл		
Сум, дүүрэг		
Байршил (Нийслэл-1, Аймагийн төв-2, Тосгон-3, Сумын төв-4, Хөдөө-5)		
Оршин суугаа хаяг		

### 1. ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО, насны бүлэг

Үзүүлэлт	м/д	Бүгд	Насны бүлэг					
			0-4	5-9	10-14	15	16	17
А	Б	1	2	3	4	5	6	7
Бүтэн өнчин хүүхдийн тоо	1							
Эмэгтэй	2							
Хагас өнчин хүүхдийн тоо	3							
Эмэгтэй	4							

Шалгалт: Багана1= Багана (2:7)

### 2. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХ /ЭЦЭГ/, гишүүдийн тоо

Үзүүлэлт	м/д	Бүгд	Өрхийн гишүүдийн тоо		
			3 хүртэлх	3-5	6, түүнээс дээш
А	Б	1	2	3	4
Өрх толгойлсон эх /эцэг/	1				
Эх	2				
Эцэг	3				

Шалгалт: Мөр1= Мөр (2:3)

Багана1= Багана (2:4)

### 3. АРВАН НАЙМ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХ /ЭЦЭГ/, хүүхдийн тоо

Үзүүлэлт	м/д	Бүгд	Хүүхдийн тоо		
			3 хүртэлх	3-5	6, түүнээс дээш
А	Б	1	2	3	4
Арван найм хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/	1				
Эх	2				
Эцэг	3				

Шалгалт: Мөр1= Мөр (2:3)

Багана1= Багана (2:4)

4.

Үзүүлэлт	м/д	Бүгд
А	Б	1
Ихэр хүүхэдтэй өрхийн тоо	1	
2 ихэр хүүхдийн тоо	2	
3, түүнээс дээш ихэр хүүхдийн тоо	3	
18 хүртэлх насны 4, түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо	4	
4 хүүхэдтэй өрхийн тоо	5	
5 хүүхэдтэй өрхийн тоо	6	
6 хүүхэдтэй өрхийн тоо	7	
7, түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо	8	
6, түүнээс дээш гишүүнтэй өрхийн тоо	9	
Ганц биеэрээ амьдарч буй ахмад настай өрхийн тоо	10	
60, түүнээс дээш настай эрэгтэй	11	
55, түүнээс дээш настай эмэгтэй	12	
Тэтгэвэр, тэтгэмж тогтоогдоогүй ахмад настай хүний тоо	13	
60, түүнээс дээш настай эрэгтэй	14	
55, түүнээс дээш настай эмэгтэй	15	

: Мөр1= Мөр (2:3)

Мөр10= Мөр (11:12)

Мөр13= Мөр (14:15)

**5. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, төрөл, хэлбэр, хүйсээр**

Үзүүлэлт	М/Д	Бүгд	Эмэгтэй	Хөгжлийн бэрхшээлийн төрөл					
				Төрөлхийн	Олдмол			Ахуйн осол	
					Өвчнөөр		Осол гэмтлээр		
А	Б	1	2	3	4	5	6	7	8
Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	1								
Хүүхдийн тоо	0-14 настай	2							
	15-17 настай	3							
Харааны	4								
Хүүхдийн тоо	0-14 настай	5							
	15-17 настай	6							
Ярианы	7								
Хүүхдийн тоо	0-14 настай	8							
	15-17 настай	9							
Сонсголын	10								
Хүүхдийн тоо	0-14 настай	11							
	15-17 настай	12							
Хөдөлгөөний	13								
Хүүхдийн тоо	0-14 настай	14							
	15-17 настай	15							
Сэтгэцийн	16								
Хүүхдийн тоо	0-14 настай	17							
	15-17 настай	18							
Хавсарсан	19								
Хүүхдийн тоо	0-14 настай	20							
	15-17 настай	21							
Бусад	22								
Хүүхдийн тоо	0-14 настай	23							
	15-17 настай	24							
Тэргэнцэртэй хүний тоо	25								
Хүүхдийн тоо	0-14 настай	26							
	15-17 настай	27							
Байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	28								
Хүүхдийн тоо	0-14 настай	29							
	15-17 настай	30							
Тэтгэвэр тэтгэмж тогтоолгосон хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	31								
Сургуульд суралцдаггүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо	32								
Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	33								
Тэтгэврийн насны хүний тоо	34								
Хөдөлмөр эрхэлдэггүй хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	35								

Шалгалт: Мөр1= Мөр (4+7+10+13+16+19+22+25+28+31+32+33+35)

Багана 1=Багана (3:8)

Мэдээг гаргасан:

..... /Албан тушаал/ ..... /Гарын үсэг/ ..... /Нэр/

Мэдээг хянасан:

..... /Албан тушаал/ ..... /Гарын үсэг/ ..... /Нэр/

20.... оны .... сарын .... Өдөр

## **МАЯГТ НЗҮ-1-ийг НӨХӨХ ЗААВАР**

Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ нь нийгмийн халамж анхаарал зайлшгүй шаардлагатай бүлгийн тоо мэдээг гаргах, улмаар тэдгээрт чиглэсэн халамжийн бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлж үнэлэхэд оршино.

### **Хаягийн хэсэгт:**

Аймаг, нийслэл, сум, дүүрэг, байршлын холбогдох кодыг ХАОСТ-2010 оны нөхөх зааврын 118 дугаар хуудасны Хавсралт 1-ээс харж нөхнө. Оршин суугаа хаяг, утасны дугаарыг бичнэ.

**Байршил:** Хөдөөгийн хүн амд сумын төв болон хөдөөд оршин суугаа хүн орно. Харин аймгийн төв, тосгонд амьдардаг хүмүүсийг хотын хүн амд хамруулна.

Хот нь 15000-аас доошгүй оршин суугчтай, тэдгээрийн дийлэнх хувь нь голлон үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэц хөгжсөн, өөрийн удирдлага бүхий суурин газар мөн / Монгол Улсын Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1/.

Тосгон 500-15000 оршин суугчтай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуучлал, амралт сувилал, тээвэр, худалдаа зэрэг салбарын аль нэг нь хөгжсөн, өөрийн удирдлага бүхий суурин газар мөн /Монгол Улсын Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2/.

**Өрх:** Ганц бие болон нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо ураг төрлийн холбоотой, хамаатан садан, зарим гишүүд нь огт хамааралгүй, эсвэл эдгээрийн аль алианаас бүрдсэн байж болно. Өрх гэдэг нь гэр бүл гэсэн ойлголтоос ялгаатай. Нэг өрхөд нэг болон хэд хэдэн гэр бүл амьдарч байж болно.

**Өрхийн ам бүлийн гишүүд:** Ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой болон холбоогүй, нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг хүмүүсийг тухайн өрхийн ам бүлийн гишүүн гэж үзнэ. Гэхдээ тухайн өрх айлд өрхийн ам бүлийн гишүүдээс нь гадна түүнд хамаарахгүй садан төрөл, бусад хүмүүс амьдарч болно. Түүнээс гадна өөр газар амьдарч, ажиллаж (хугацаат цэргийн алба хааж байгаа, өөр аймаг, нийслэлд сурч байгаа оюутан сурагчид, түр хугацаагаар гадаад, дотоодод явагчид гэх мэт) байгаа өрхийн ам бүлийн гишүүд орно.

### **Хүснэгт 1. Өнчин хүүхдийн тоо, насны бүлэг:**

“Бүтэн өнчин хүүхэд” гэж эцэг, эх нь тогтоогдоогүй, эсвэл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх /эцэг/ нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг хамруулна /Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7/.

### **Хүснэгт 2. Өрх толгойлсон эх /эцэг/, гишүүдийн тоо:**

“Өрх толгойлсон эх /эцэг/” гэж нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсвэл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, гэрлэлтээ цуцлуулсан, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие эх /эцэг/-ийг хамааруулна /Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8/.

Хэрэв амьдралын шаардлагаар нөхөр, эхнэр нь тусдаа өөр аймаг, нийслэлд амьдарч байгаа хүнийг өрх толгойлсон эх /эцэг/-т хамруулахгүй.

### **Хүснэгт 3. Арван найм хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/, хүүхдийн тоо:**

18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/-ийн тоог тодорхойлохдоо нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсвэл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, гэрлэлтээ цуцлуулсан, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй өрх толгойлсон эх/эцэг/-ийг төрөл, садангийн хэнтэй хамт амьдардагийг харгалзахгүйгээр хүүхдийн тоогоор гаргана.

### **Хүснэгт 4. Өрхийн зарим үзүүлэлт:**

Ихэр хүүхэдтэй өрхийн тоог гаргахдаа хэрэв тухайн өрх 2 ихэр хүүхэдтэй, 3, түүнээс дээш ихэр хүүхэдтэй хүүхдийн тоог сугалж гаргах ба хүүхэд тус бүрийн тоогоор авч бүртгэнэ. Ганц биеэрээ амьдарч буй ахмад настай өрх, нийгмийн даатгалын болон аж ахуйн нэгж байгууллагаас ямар нэгэн тэтгэвэр, тэтгэмж тогтоогдоогүй ахмад настай хүний тоог гаргахдаа 60, түүнээс дээш насны эрэгтэй, 55, түүнээс дээш насны эмэгтэйг хамруулна.

## **МАЯГТ НЗҮ-1-ийг НӨХӨХ ЗААВАР ҮРГЭЛЖЛЭЛ**

### **Хүснэгт 5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, төрөл, хэлбэр, хүйс**

Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг “хөгжлийн бэрхшээлтэй” гэж ойлгоно /Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1/.

Хөдөлмөр магадлах комиссоор хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлогдсон хүнийг хамруулна.

Хөгжлийн бэрхшээлийн төрлийг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

**Төрөлхийн:** Хөгжлийн бэрхшээлийн төрөлд удамшлын эмгэг, согог, жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалан бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамруулна.

**Олдмол:** Хөгжлийн бэрхшээлийн төрөлд ахуйн болон үйлдвэрлэлийн осол, гэмтэл, ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамруулна.

Хөгжлийн бэрхшээлийн илэрсэн хэлбэрийг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

**Харааны:** Харааны эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “харах” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг хамруулна.

**Ярианы:** Хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин, эмгэгийн улмаас хүний “ярих” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг хамруулна.

**Сонсголын:** Сонсголын болон хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “сонсох” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг хамруулна.

**Хөдөлгөөний:** Биеийн тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадваргүй хүнийг хамруулна.

**Сэтгэцийн:** Сэтгэцийн эмгэг нь бодох сэтгэх, мэдрэх ухамсарлахуйн болон зан төлвийн өөрчлөлтөөр илрэх бөгөөд үүнийхээ улмаас хүний нийгэмд биеэ авч явах байдал нь өөрчлөгдсөн, гадаад (төрөх үеийн хүндрэлүүдийн үлдэцийн улмаас 0-3 насанд тэнэгрэх) болон дотоод (хромосомын өөрчлөлт, бодисын солилцоо дутмагшил гэх мэт) шалтгааны улмаас ойлгох, сэтгэх, мэдрэх үйл ажиллагаа нь хязгаарлагдсан хүнийг хамруулна.

**Хавсарсан:** Нэг хүнд нэгээс дээш төрлийн хөгжлийн бэрхшээлтийн хэлбэр, согог тохиолдвол хавсарсан хөгжлийн бэрхшээлд хамруулна /Тухайлбал: сэтгэцийн, хөдөлгөөний, ярианы бэрхшээлтэй байж болно гэх мэт/.

**Бусад:** Ямар нэгэн эмгэг болон өвчний улмаас өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх чадвараа алдсан хүнийг үүнд хамруулна /Тухайлбал: дотор эрхтний эмгэгүүд хавдар гэх мэт/.

**Сургуульд суралцдаггүй хүүхдийн тоо:** Албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд хамрагдаж буй хүүхдийг сургуульд сурдаг гэж үзнэ. Харин ямар нэг шатны боловсрол олгодоггүй албан бус боловсролын сургалтанд хамрагдагчдыг сургуульд суралцдаггүй хүүхдийн тоонд хамруулах бөгөөд үүнээс сургуульд суралцдаггүй хүүхдийн тоог гаргана.

**Албан бус боловсролын сургалт:** Сургуулиас гадуурх зохион байгуулалттай сургалтын үйл ажиллагааг хэлэх бөгөөд үүнд, төрөл бүрийн мэргэжил олгох (жолоо, гадаад хэл, тогооч, компьютерийн гэх мэт) эсвэл амьдрах ухаанд сургах (ногоо тарих, алт мөнгөний дархан) зэрэг алсын зайн сургалтыг хамруулна.